



**1972 оны Биологийн болон токсинь зэвсгийн
тухай конвенц, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн
1540 дүгээр тогтоолын холбогдох
шаардлагуудыг үндэсний хэмжээнд
хэрэгжүүлэхэд зориулсан жишиг хууль**

УДИРТГАЛ

Энэхүү "Жишиг хууль"-ийг 1972 оны Биологийн болон токсины зэвсгийн тухай конвенц, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1540 дүгээр тогтоолын биологийн зэвсэгтэй холбоотой заалтыг хэрэгжүүлэх хууль тогтоомжийн төслийг боловсруулахад улс орнуудад туслах зорилгоор боловсруулсан. Энэ нь хуулийн төсөл боловсруулагч нар улс орныхоо хууль, эрх зүйн орчин, био технологийн хөгжлийн түвшин, үндэсний бусад нөхцөл байдлыг харгалзан чөлөөтэй ашиглаж болох хэрэгсэл юм.

Биологийн ба токсины зэвсгийн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлж хориглох тухай хууль тогтоомж нь төрийн бус оролцогчийн биологийн бодис ба токсиныг буруугаар ашиглах гэмт хэрэг, түүнд хүлээлгэх шийтгэл, мөн хууль ёсны үйл ажиллагааг үр дүнтэйгээр зохицуулах боломжийг тухайн улсад олгосон заалтуудыг багтаасан байвал зохино. Энэхүү хоёр арга хамтдаа өвчнийг санаатайгаар алдагдуулах замаар айдас ба самуун, гэмтэл ба үхлийг дэлгэрүүлж болзошгүй этгээдүүдийг найдвартай хазаарлан тогтоох хэрэгслийг бий болгоно.

Жишиг хуулийн А хэсэгт товч удиртгал байгаа бөгөөд хууль тогтоомжид тодорхой утга бүхий нэр томъёонуудыг тодорхойлсон. Б хэсэгт хорлох эсвэл алахын тулд биологийн бодис, токсиныг буруугаар ашигласан төрийн бус оролцогчийг хуулиар шийтгэл хүлээлгэвэл зохих гэмт хэрэг үйлдсэн гэдгийг баталгаажуулж өгсөн. Ялангуяа 5 дугаар бүлэгт биологийн зэвсэгтэй холбоотой үйл ажиллагаа, өвчин үүсгэгч жижиг организмыг санаатайгаар алдагдуулахтай холбоотой террорист үйлдэл, зохих зөвшөөрөлгүйгээр дотоод болон олон улсад шилжүүлэх зэрэг хязгаарласан биологийн бодис, токсинтой холбоотой тодорхой үйл ажиллагааг хориглосон. 6 дугаар бүлэгт оролдлого, тусламж, санхүүжилт эсвэл аюул занал зэргийг багтаасан жижиг өвчин үүсгэгч организаар хорлох эсвэл алахад чиглэсэн аливаа бэлтгэл ажиллагаа бол хуулиар шийтгэл хүлээлгэвэл зохих гэмт хэрэг мөн гэдгийг баталгаажуулж өгсөн.

Жишиг хуулийн В хэсэгт биологийн болон токсины зэвсгийг дэлгэрүүлэхээс урьдчилан сэргийлэхэд зориулсан био аюулгүй байдлын арга хэмжээг бүхий хүчирхэг, иж бүрэн системийг тогтоож өгсөн. 9, 10 дугаар бүлэгт тухайн улсын зүгээс хяналтын системээр дамжуулан хянахыг хүсэж байгаа биологийн бодис, токсин, тоног төхөөрөмж, технологийн жагсаалтыг бий болгох замаар урьдчилан сэргийлэх үндсэн арга хэмжээний талаар өгүүлсэн. 11-14 дүгээр бүлэгт хязгаарласан бодис, токсинтой холбоотой үйл ажиллагаа, дотоод шилжүүлгийн мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагаа, хязгаарласан бодис, токсин, тоног төхөөрөмж, технологийн олон улсын шилжүүлгийн импорт/экспортын зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох замаар болон эдгээр зүйлсийг тээвэрлэхээр батлагдсан зөвөрлөгчийн хатуу хяналтаар дамжуулан гэмт хэргийг таслан зогсоох сүлжээг бий болгосон.

15, 16 дугаар бүлэгт санал болгосон хоёр агентлагийн явуулах хууль сахиулах ажиллагаа, хяналтын тухай Г хэсэгт заасан. Эхнийх нь ерөнхий бодлогын зохицуулалт ба үндэсний түвшинд хууль тогтоомж, аливаа зохицуулалтыг хэрэгжүүлэх ажлыг хариуцсан байгууллага хоорондын этгээд буюу хариуцлагатай эрх бүхий байгууллага юм. Хоёр дахь нь байгалийн, санамсаргүй буюу санаатайгаар өвчин дэгдээсэн тохиолдолд нийтийн эрүүл мэндийг зохицуулж, хууль сахиулах хариу арга хэмжээг хариуцсан Биологийн онцгой байдлын хариу арга хэмжээ, мөрдөн байцаалтыг дэмжих систем юм. Г хэсэгт мөн тусгай зөвшөөрөл авсан хувь хүн, байгууллага, тээвэрлэгчийг 17, 18 дугаар бүлэгт заасан тайлагнах шаардлагууд, тоног төхөөрөмжийн үзлэг шалгалтыг мөрдөхийг шаардаж, 22 дугаар бүлэгт хууль тогтоомжийн сэжиг бүхий зөрчлийг тусгайлан бэлтгэгдсэн мэргэжилтэн хянан шалгах тухай заасан. Б, В, Г хэсэг дэх гэмт хэрэгт хүлээлгэх шийтгэлийг 26 дугаар бүлэгт заасан. 27, 28 дугаар бүлэгт бусад улс, олон улсын

байгууллагтай өрнүүлэх эрх зүйн хамтын ажиллагаа, туслалцаанд зориулсан харьяалал, арга замыг тогтоосон. Сүүлийн Д хэсэгт зохих яам эсвэл хариуцах эрх бүхий байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд шаардлагатай аливаа дүрэм журмыг гаргах боломжийг олгосон.

VERTIC (www.vertic.org) хүсэлт гаргасан тохиолдолд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх хууль эрх зүйг нийслэл хотод боловсруулахад туслах боломжтой. Энэ үйлчилгээ үнэ төлбөргүй юм. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар хандана уу:

Баталгаажуулах судалгаа, сургалт, мэдээллийн төв (VERTIC),

Development House, 56-64 Leonard Street, London EC2A 4LT, United Kingdom
Утас: +44 (0) 20 7065 0880, Факс: +44 (0) 20 7065 0890
Имэйл: vertic.org [дахь] NIM
Вэбсайт: www.vertic.org

VERTIC бол Нэгдсэн Вант Улсын нийслэл Лондон хотод байрладаг бие даасан, ашигийн бус, төрийн бус байгууллага юм. VERTIC олон улсын гэрээний хэрэгжилтийн найдвартай байдлыг хангах зорилгоор үр дүнтэй, үр ашигтай нотолгоог дэвшүүлдэг.

Улс орнуудад цөмийн, химийн, биологийн зэвсгийн гэрээнүүдийн дагуу хүлээсэн үүрэг, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолуудтай нийцүүлэхийн тулд үндэсний түвшинд ямар арга хэмжээ авах шаардлагатай, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэхийг ойлгоход нь туслах зорилгоор VERTIC-ын Үндэсний Хэрэгжүүлэх Арга Хэмжээний (NIM) Хөтөлбөрийг боловсруулсан.

VERTIC байгууллага энэ хөтөлбөрт зориулж санхүүгийн болон бодит дэмжлэг үзүүлсэн Канад улсын засгийн газар (Гадаад харилцаа, худалдаа, хөгжлийн яамны Олон улсын хамтын ажиллагааны хөтөлбөр) ,Нэгдсэн Вант Улсад (Гадаад харилцаа, хамтын нөхөрлөлийн яамны Стратегийн хөтөлбөрийн сан) талархлаа илэрхийлэхийг хүсэж байна. VERTIC-ийн илэрхийлсэн үзэл бодол эдгээр засгийн газар болон агентлагийн үзэл бодлыг заавал илэрхийлэхгүй.

Хэдийгээр энэ жишиг хуулийг бэлтгэхдээ анхаарвал зохих бүх зүйлийг харгалзан үзсэн боловч үүнийг аливаа байдлаар ашигласнаас үүдэн гарсан аливаа хариуцлага эсвэл үүргээс VERTIC чөлөөлөгдөнө. Ямар нэгэн алдаа эсвэл орхигдуулсан зүйлийг бидэнд мэдэгдвэл талархах болно.

Хувилбар: 2012 оны хоёрдугаар сар

1972 оны Биологийн болон токсинь зэвсгийн тухай конвенц ба [ОН] оны НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1540 дүгээр тогтоолын холбогдох шаардлагуудыг хэрэгжүүлэх [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]

[УЛСЫН НЭР] улсын [ПАРЛАМЕНТ, ҮНДЭСНИЙ АССАМБЛЕЙ]-аас баталж, [ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮН, ТӨРИЙН ТЭРГҮҮН]

[ОГНОО]-ний өдөр гарын үсэг зурсан

БҮЛГҮҮДИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

А ХЭСЭГ УРЬДЧИЛСАН ГЭРЭЭ

- 1 Товч гарчиг
- 2 Зорилго
- 3 Тухайн улсын заавал дагаж биелүүлэх [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]
- 4 Тайлбар

Б ХЭСЭГ ХОРИГ

- 5 Биологийн бодис,токсины зүй бус ашиглалт
- 6 Альтернатив эрүүгийн хариуцлага
- 7 Албан тушаалтны өмгөөллийг хориглох

В ХЭСЭГ БИО АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- 8 Зорилго
- 9 Хязгаарласан бодис, токсин
- 10 Хязгаарласан тоног төхөөрөмж,технологи
- 11 Хязгаарласан бодис,токсины тусгай зөвшөөрөл
- 12 Хязгаарласан бодис, токсины тусгай зөвшөөрөл
- 13 Олон улсын шилжүүлгийн хяналт
- 14 Хязгаарласан бодис, токсины тээвэрлэлт

Г ХЭСЭГ ХУУЛЬ САХИУЛАХ

- 15 [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-ын хууль сахиулах эрх мэдэл, үүсгэн байгуулах, бүрэн эрх
- 16 [[УЛСЫН НЭР] улсын биологийн онцгой байдлын хариу арга хэмжээ, мөрдөн байцаалтыг дэмжих системийн (BERISS)] үүсгэн байгуулалт
- 17 Бүртгэлийг хадгалж тайлагнах, холбогдох гэмт хэрэг
- 18 Хяналт шалгалт
- 19 Байцаагчийн үүрэг
- 20 Байрыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн үүрэг, холбогдох гэмт хэрэг
- 21 Хамгаалалтын арга хэмжээ авах шаардлагатай чиглэл, холбогдох гэмт хэрэг
- 22 Мөрдөн байцаалт
- 23 Хурааж устгах
- 24 Тодорхой үйл ажиллагааг зогсоох шүүхийн шийдвэр
- 25 Гэмт хэргийг үргэлжлүүлэх
- 26 Эрүүгийн болон иргэний шийтгэл
- 27 Хэрэгжилт
- 28 Хууль эрх зүйн хамтын ажиллагаа ба туслалцаа

Д ХЭСЭГ ЗОХИЦУУЛАЛТ

29 Зохицуулалт
A ХЭСЭГ УРЬДЧИЛСАН ГЭРЭЭ

1. Товч гарчиг

Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийг [[ЖИЛ] ОНЫ БИОЛОГИЙН БОЛОН ТОКСИНЫ ЗЭВСГИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]] гэж эш татаж болно.

2. Зорилго

Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн зорилго нь биологийн бодис, токсинг буруугаар ашиглахыг хориглох, био аюулгүй байдлыг дэмжиж, биологийн ба токсин зэвсгийг дэлгэрүүлэхээс урьдчилан сэргийлэх олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь [УЛСЫН НЭР] улсад туслалцаа үзүүлэх замаар 1972 оны Биологийн ба токсин зэвсгийн тухай конвенц, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1540 дүгээр тогтоолын биологийн зэвсэгтэй зэвсэгтэй холбоотой заалтуудыг хэрэгжүүлэхэд оршино. Б хэсэгт биологийн бодис, токсин зүй бус хэрэглээнд тавих хориг, холбогдох гэмт хэргийг тодорхойлсон. В хэсэгт тодорхой биологийн бодис, токсин, тоног төхөөрөмж, технологи, холбогдох гэмт хэргийг заасан. Г хэсэгт энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн дагуу ногдуулах шийтгэл, албадлагын тухай заасан. Д хэсэгт [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн дагуу хэрэгжүүлэх зохицуулалтын тухай заасан.

3. Тухайн улсын заавал дагаж биелүүлэх [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]

Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийг [УЛСЫН НЭР] улс заавал дагаж биелүүлнэ.

4. Тайлбар

(1) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-д –

- (a) “Биологийн эсвэл токсин зэвсэг” гэж –
 - i. гарал үүсэл, үйлдвэрлэсэн аргаас үл хамаарч урьдчилан сэргийлэх, хамгаалах болон энх тайвны бусад зориулалтын бус төрөл, тоо хэмжээний бичил биологийн, биологийн бусад бодис буюу токсин;
 - ii. ийм бодис, токсинг дайсагнасан зорилго буюу зэвсэгт мөргөлдөөнд ашиглахад зориулсан зэвсэг, тоног төхөөрөмж, зөөгч хэрэгслийг хэлнэ;
- (b) "Хязгаарласан бодис, токсин" болон "Хязгаарласан бодис, токсин жагсаалт"-ыг энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн 9 дүгээр бүлэгт өгсөн утгаар тус тус ойлгоно;
- (c) "Хязгаарласан тоног төхөөрөмж, технологи" болон "Хязгаарласан тоног төхөөрөмж, технологийн жагсаалт"-ыг энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн 10 дугаар бүлэгт өгсөн утгаар тус тус ойлгоно;
- (d) "Байгууллага" гэж аливаа засгийн газрын агентлаг, боловсролын байгууллага, корпораци, компани, түншлэл, нийгэмлэг, холбоо, пүүс, хувиараа аж ахуй эрхлэгч эсвэл бусад хуулийн этгээдийг хэлнэ;
- (e) "Хувь хүн" гэж хувь хүн эсвэл дотоод хуульд нийцсэн хэмжээнд эрүүгийн хариуцлага хүлээх аливаа хуулийн этгээдийг хэлнэ;

- (f) "Хариуцах эрх бүхий байгууллага" гэж [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн 15 дугаар бүлгийн дагуу байгуулагдсан этгээдийг хэлнэ;
- (g) "Газар нутаг" гэж [УЛСЫН НЭР] улсын дотор орших эсвэл түүний харьяалал эсвэл хяналтад байгаа аливаа бүсийг хэлнэ.

(2) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] нь энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн зорилгоор "биологийн бодис", "токсин", "тоног төхөөрөмж", "технологи"-ийг тодорхойлох дүрэм журмыг гаргаж болно.

Б ХЭСЭГ ХОРИГ

5. Биологийн бодис, токсины зүй бус ашиглалт

(1) Дараах үйлдлийг санаатайгаар үйлдсэн этгээд бүрийг гэмт хэрэг үйлдсэнд тооцно –

- (a) аливаа биологийн эсвэл токсины зэвсгийг боловсруулсан, үйлдвэрлэсэн, олж авсан, нөөцөлсөн, эзэмшсэн, тээвэрлэсэн, хадгалсан эсвэл биологийн эсвэл токсины зэвсгийг хэн нэгэнд шууд ба шууд бусаар шилжүүлсэн;
- (b) аливаа биологийн эсвэл токсины зэвсгийг ашигласан;
- (c) биологийн эсвэл токсины зэвсгийг ашиглахаар бэлтгэх ажилд оролцсон;
- (d) биологийн эсвэл токсины зэвсгийг үйлдвэрлэх зорилгоор аливаа тоног төхөөрөмжийг бүтээсэн, олж авсан эсвэл хадгалсан; эсвэл
- (e) аливаа биологийн бодис эсвэл токсиноор зэвсэглэсэн.

(2) Улс төр эсвэл нийгмийн зорилгоор засгийн газар эсвэл энгийн иргэдийг айлган сүрдүүлэх, хүчирхийлэхийн тулд хүн төрөлхтөн, амьтан, ургамлыг хордуулах эсвэл алах зорилгоор биологийн бодис эсвэл токсиныг санаатайгаар алдагдуулсан этгээд бүрийг гэмт хэрэг үйлдсэнд тооцно.

(3) Дараах үйлдлийг үйлдсэн этгээд бүрийг гэмт хэрэг үйлдсэнд тооцно –

- (a) Хязгаарласан бодис эсвэл токсиныг боловсруулсан, олж авсан, үйлдвэрлэсэн, эзэмшсэн, хадгалсан, тээвэрлэсэн, шилжүүлсэн эсвэл ашигласан –
 - i. энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн 11 дүгээр бүлгийн дагуу [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас тусгай зөвшөөрөл авалгүйгээр,
 - ii. энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн 11 дүгээр бүлгийн дагуу [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас олгосон тусгай зөвшөөрлийн нөхцөлүүдийг зөрчин эсвэл
 - iii. энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн 11 дүгээр бүлгийн аливаа бусад заалтуудыг зөрчин;
- (b) энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн 12 дугаар бүлгийн дагуу [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас тусгай зөвшөөрөл аваагүй хувь хүн эсвэл байгууллагад [УЛСЫН НЭР] улсын дотор Хязгаарласан бодис эсвэл токсиныг шилжүүлсэн эсвэл шилжүүлгийн талаар [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-д мэдэгдээгүй;
- (c) аливаа Хязгаарласан бодис, токсин эсвэл хязгаарласан тоног төхөөрөмж, технологийг [УЛСЫН НЭР] улсын газар нутгаар дамжуулан импортлох, экспортлох, дахин экспортлох, шилжүүлэн ачих –

- i. энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн 13 дугаар бүлгийн дагуу [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас олгосон шилжүүлэх зөвшөөрөлгүйгээр, эсвэл
 - ii. энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн 13 дугаар бүлгийн дагуу эцсийн хэрэглэгчийн гэрчилгээ байхгүй;
- (d) хязгаарласан бодис эсвэл токсиньг зөвшөөрөгдсөн тээвэрлэгчээр дотооддоо буюу олон улсад шилжүүлж чадаагүй эсвэл 14 дүгээр бүлгийн аливаа бусад заалтуудыг биелүүлээгүй;
 - (e) энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ] ба үүнтэй түүний дагуу гаргасан аливаа дүрэм журам эсвэл бусад аливаа [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-д зааснаас гадуур аливаа хязгаарласан бодис эсвэл токсиньг судалгаа, үйлдвэрлэлд зориулсан аливаа тоног төхөөрөмжийг зохион бүтээх, олж авах эсвэл хадгалах;
 - (f) хязгаарласан бодис эсвэл токсиньг агуулсан аливаа тоног төхөөрөмж, савлагаа, агуулах савнаас алдагдуулах зорилгоор оролдох; эсвэл
 - (g) эдгээр хязгаарласан бодис, токсиньг алдагдуулахын тулд тоног төхөөрөмж эсвэл зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслээс хязгаарласан бодис, токсиньг хулгайлах эсвэл чиглэлийг нь өөрчлөх эсвэл хязгаарласан бодис, токсиньг агуулсан зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслийг хяналтдаа авах буюу ашиглах.

6. Альтернатив эрүүгийн хариуцлага

Дараах үйлдлийг үйлдсэн этгээд бүрийг гэмт хэрэг үйлдсэнд тооцно –

- (a) 5 дугаар бүлгээр хориглосон аливаа үйл ажиллагааг явуулахад хэн нэгэнд ямар нэг байдлаар туслах, дэмжих, өдөөх;
- (b) 5 дугаар бүлгээр хориглосон аливаа үйл ажиллагааг явуулахыг хэн нэгэнд тушаах эсвэл зааварлах;
- (c) 5 дугаар бүлгээр хориглосон аливаа гэмт хэргийг үйлдэхийг завдах;
- (d) 5 дугаар бүлгээр хориглосон аливаа гэмт хэргийг үйлдэхийг хүчээр тулгах; эсвэл
- (e) 5 дугаар бүлгээр хориглосон аливаа үйл ажиллагааны санхүүжүүлэгч эсвэл хамсаатан болж ажиллах;

7. Албан тушаалтны өмгөөллийг хориглох

Дээд удирдлагын тушаал буюу зааварчилгаа эсвэл дотоодын хуулийн дагуу албан тушаалтан эрх мэдлээ ашиглаж үйлдсэн нь энэ хэсэгт заасан гэмт хэрэгт яллагдсан этгээдийг өмгөөлөх үндэслэл болохгүй.

В ХЭСЭГ БИО АЮУЛГҮЙ БАЙДАЛ

8. Зорилго

В хэсэгт тодорхой биологийн бодис, токсинь боловсруулалт, худалдан авалт, үйлдвэрлэл, эзэмшил, тээвэрлэлт, хадгалалт эсвэл тодорхой хоёрдмол хэрэглээтэй биологийн тоног төхөөрөмж, технологийн шилжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавина. В хэсгийн зорилго эдгээр бодис, токсин, тоног төхөөрөмж, технологийг [УЛСЫН НЭР] улсад аюулгүй, найдвартай хяналт тавих нөхцөл бүрдүүлэхэд оршино. Ялангуяа энэ хэсэг, түүнийг

хэрэгжүүлэх дүрэм журам хязгаарласан бодис, токсины хулгайлах, алдагдах, өөрчлөх, хууль бус наймаалах эсвэл бусад зохисгүй зайлуулахаас урьдчилан сэргийлэхэд зориулалттай.

9. Хязгаарласан бодис ба токсин¹

1-р сонголт: [(1) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] нь дараах шалгуурт үндэслэн нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдалд ноцтой аюул учруулах биологийн бодис, токсины жагсаалтыг бий болгож, хөтөлнө –

- (a) хүн, амьтан эсвэл ургамлын эрүүл мэнд эсвэл амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд үзүүлэх нөлөө;
- (b) халдварлах түвшин, дамжих арга зам;
- (c) эмийн эмчилгээ хийх, дархлаажуулах боломжтой эсэх, үр дүнтэй байдал;
- (d) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] эдгээр аливаа шалгуурын хэрэглээг олон нийтэд мэдэгдэж, тайлбарлах тохиолдолд зохистой (хэрэв байгаа бол) гэж үзсэн бусад шалгуур.

(2) Энэ бүлгийн дагуу тодорхойлсон жагсаалтын биологийн бодис, токсиныг "хязгаарласан бодис ба/эсвэл токсин" гэж нэрлэх бөгөөд эдгээр бодис, токсины жагсаалтыг "хязгаарласан бодис, токсины жагсаалт" гэнэ. Хязгаарласан бодис, токсины жагсаалт энэ бүлгийн дагуу гаргасан дүрэм журамд багтах бөгөөд [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] нь тогтмол хянаж, шаардлагатай бол өөрчилж байна.]

2-р сонголт: [(2) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] эрсдэлийн бүлгээрх халдварт бичил организмын Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын ангилалд үндэслэн биологийн бодис, токсины жагсаалтыг тодорхойлж, хөтөлнө.² Энэ жагсаалт, үүнийг тодорхойлоход ашиглагдсан удирдамж энэ бүлгийн дагуу гаргасан дүрэм журамд багтах бөгөөд [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] тогтмол хянаж, шаардлагатай бол өөрчилж байна.]

(2) Энэ бүлгийн дагуу тодорхойлогдсон жагсаалт дахь [1,] [2,] [3,] [ба] [4]-р эрсдэлийн бүлэг[үүд] дэх биологийн бодис, токсиныг "хязгаарласан бодис ба/эсвэл токсин" гэх бөгөөд эдгээр бодис, токсины жагсаалтыг "хязгаарласан бодис, токсины жагсаалт" гэнэ.

¹ Энэ жишиг хуулийн тусгай зөвшөөрлийг олгох, тайлагнах, хянах шалгах дэглэмээр дамжуулан [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-ын зүгээс хянах биологийн бодис, токсины жагсаалтыг бэлтгэх хоёр сонголтгоор хангах: нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулахтай холбоотой шалгуурт үндэслэсэн жагсаалт эсвэл Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын дөрвөн эрсдэлийн бүлгийн ангилалд үндэслэсэн жагсаалт. Хүссэн тохиолдолд одоо байгаа жагсаалтын жишээг өгөх боломжтой.

² Лабораторийн биологийн аюулгүй байдлын гарын авлага (Гурав дахь хэвлэл), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, 2004. Удирдамж нь:

Эрсдэлийн бүлэг 1 (хувь хүн, олон нийтэд учруулах эрсдэл байхгүй эсвэл бага): Хүн эсвэл амьтанд өвчин үүсгэх бага магадлалтай бичил организм.

Эрсдэлийн бүлэг 2 (хувь хүнд учруулах эрсдэл дунд зэрэг, олон нийтэд учруулах эрсдэл бага): Эмгэг үүсгэгч нь хүн, амьтанд өвчин үүсгэж чадах боловч лабораторийн ажилтан, олон нийт, мал аж ахуй эсвэл байгаль орчинд ноцтой аюул учруулах магадлал бага. Лабораторийн нөхцөлд өртөхөд ноцтой халдварыг үүсгэж болох боловч үр дүнтэй эмчилгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломжтой бөгөөд халдварын тархах эрсдэл нь хязгаарлагдмал юм.

Эрсдэлийн бүлэг 3 (хувь хүнд учруулах эрсдэл өндөр, олон нийтэд учруулах эрсдэл бага): Эмгэг үүсгэгч нь гол төлөв хүн, амьтанд ноцтой өвчин үүсгэдэг боловч ердийн үед халдвар авсан нэг хүнээс нөгөөд халдварладаггүй. Үр дүнтэй эмчилгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломжтой.

Эрсдэлийн бүлэг 4 (хувь хүн, олон нийтэд учруулах эрсдэл өндөр): Эмгэг үүсгэгч нь гол төлөв хүн, амьтанд ноцтой өвчин үүсгэдэг ба энэ нь нэг хүнээс нөгөөд шууд ба шууд бусаар халдварлах боломжтой. Үр дүнтэй эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ гол төлөв байхгүй байдаг.

10. Хязгаарласан тоног төхөөрөмж, технологи

(1) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] биологийн тоног төхөөрөмж, технологийн хоёрдмол ашиглалтын жагсаалтыг тодорхойлж, хөтөлнө.³

(2) Энэ бүлгийн дагуу тодорхойлсон жагсаалт дээрх биологийн бодис, токсиныг "хязгаарласан тоног төхөөрөмж ба/эсвэл технологи" гэх бөгөөд эдгээр бодис, токсины жагсаалтыг "хязгаарласан тоног төхөөрөмж, технологийн жагсаалт" гэнэ. Хязгаарласан тоног төхөөрөмж, технологийн жагсаалт энэ бүлгийн дагуу гаргасан дүрэм журамд багтах бөгөөд [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] тогтмол хянаж, шаардлагатай бол өөрчилж байна.]

11. Хязгаарласан бодис, токсинд тусгай зөвшөөрөл олгох

Тусгай зөвшөөрөл олгох

(1) Хязгаарласан бодис эсвэл токсиныг боловсруулах, олж авах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх эсвэл ашиглах хувь эсвэл байгууллага бүр энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн дагуу гаргасан зохицуулалтад нийцүүлэн [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас тусгай зөвшөөрөл авсан байна. Энэ бүлгийн дагуу тусгай зөвшөөрөл авч байгаа хувь хүн, байгууллага эдгээр хязгаарласан бодис эсвэл токсиныг боловсруулах, олж авах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх эсвэл ашиглах хууль ёсны зорилготой байх ёстой.

(2) Энэ бүлгийн дагуу олгосон тусгай зөвшөөрөлд хувь хүн, байгууллагад боловсруулах, олж авах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх эсвэл ашиглах эрх олгосон хязгаарласан бодис эсвэл токсин бүрийг жагсаана.

(3) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн дагуу гаргасан зохицуулалт тохиромжтой нөхцөлд, үүний дотор энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийг зөрчсөн аливаа тохиолдолд [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох заалттай байна.

(4) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн дагуу гаргасан зохицуулалтын жагсаалтын дагуу олгохыг хориглосон хувь хүн, байгууллагад [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас тусгай зөвшөөрөл олгохгүй.

Тусгай зөвшөөрөл авах үүргээс чөлөөлөх

(5) Зөвхөн [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] нийтийн эрүүл мэнд, хөдөө аж ахуйн онцгой байдал, нотлох баримт бүрдүүлэх зорилгоор эсвэл хоол хүнс, эм, гоо сайхан, шавьж устгах бодис эсвэл ижил төстэй хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан бүтээгдэхүүнийг энэ бүлгийн дагуу тусгай зөвшөөрөл авах үүргээс чөлөөлнө.

Байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, хуулийн хэрэгжилт хариуцсан ажилтан

(6) Байгууллагын тусгай зөвшөөрлийн өргөдөлд тухайн байгууллагыг эзэмшигч этгээд эсвэл хяналтын талаарх мэдээллийг багтаана. Энэ бүлгийн дагуу тусгай зөвшөөрөл хүсэж байгаа аливаа байгууллага зөвшөөрөл олгох нөхцөлийг хангах зорилгоор [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ], үүнтэй хамаатуулан гаргасан дүрэм журмыг сахин биелүүлэхийн тулд үйлдвэр бүрд хувь хүнийг "хуулийн хэрэгжилт хариуцсан ажилтан"-аар томилж, эрх олгон [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-д мэдэгдэнэ. Хуулийн хэрэгжилт хариуцсан

³ Хүссэн тохиолдолд одоо байгаа жагсаалтын жишээг өгөх боломжтой.

ажилтан [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ], үүнтэй хамаатуулан гарсан дүрэм журмыг хэрэгжүүлэхийн тулд үйлдвэрийг төлөөлөн үйл ажиллагаа явуулах хангалттай эрх мэдэлтэй байна. Тухайн байгууллага энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн үйлдвэрийн хуулийн хэрэгжилт хариуцсан ажилтнууд, [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-тай харилцаж, дүрэм журамд зааж болох бусад үүргийг хүлээнэ.

(7) Энэ бүлгийн дагуу тусгай зөвшөөрөл авсан аливаа байгууллага энэ бүлгийн дагуу хязгаарласан бодис эсвэл токсиньг боловсруулах, олж авах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх эсвэл ашиглах тусгай зөвшөөрлийг авсан хувь хүнд хязгаарласан бодис эсвэл токсинд нэвтрэх зөвшөөрлийг зөвхөн олгоно.

Үйлдвэрийн талаар мэдээлэх

(8) Тухайн байгууллага хязгаарласан бодис эсвэл токсиньг боловсруулж, худалдан авч, үйлдвэрлэж, эзэмшиж, хадгалж, тээвэрлэж, шилжүүлж эсвэл ашигладаг өөрийн бүх барилга байгууламж, тэнд үйлдвэрт ажиллаж байгаа тусгай зөвшөөрөлтэй хүмүүсийн талаар [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-д мэдээлнэ. [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-д мэдэгдсэн барилга байгууламжийг "мэдээлэгдсэн байгууламж" гэнэ.

Байгууллагын тусгай зөвшөөрөл, био аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа

(9) Энэ бүлгийн дагуу тусгай зөвшөөрөл авахыг хүсэж байгаа байгууллага бүр зөвшөөрөл авах нөхцөл болгож тусгай зөвшөөрөл аваагүй хүн хязгаарласан бодис эсвэл токсиньг ашиглахаас сэргийлэхийн тулд энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]⁴-ийн дагуу гаргасан био аюулгүй байдлын дүрэм журамтай мэдээлэгдсэн барилга байгууламж нь нийцнэ гэдгийг баталгаажуулна. Тус дүрэм журамд хязгаарласан бодис эсвэл токсиньг боловсруулж, олж авч, үйлдвэрлэж, эзэмшиж, хадгалж, тээвэрлэж, шилжүүлж эсвэл ашигладаг барилга байгууламжид зориулсан байрны болон ажилтнуудын аюулгүй байдлын төлөвлөгөө, байрыг хамгаалах арга хэмжээг тодорхой заана. Тус дүрэм журам хязгаарласан бодис эсвэл токсиньг боловсруулж, худалдан авч, үйлдвэрлэж, эзэмшиж, хадгалж, тээвэрлэж, шилжүүлж эсвэл ашигладаг барилга байгууламжид ажиллаж байгаа хувь хүмүүс найдвартай эсэхийг магадлахын тулд ажилтнуудын хувийн мэдээллийг шалгахыг шаардана. Байр ба хувь хүний аюулгүй байдалд тавих шаардлагууд нь хязгаарласан бодис, токсинь нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд учруулах эрсдэлтэй дүйж нийцвэл зохино.

(б) Энэ бүлгийн дагуу тусгай зөвшөөрөл авахыг хүсэж байгаа байгууллага бүр зөвшөөрөл авах нөхцөлийн хувьд хязгаарласан бодис, токсинд санамсаргүй өртөх эсвэл алдагдах ослоос урьдчилан сэргийлэхийн тулд энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]⁵-аар гаргасан био аюулгүй байдлын дүрэм журамтай мэдээлэгдсэн байгууламж нь нийцнэ гэдгийг баталгаажуулна.

[ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] бүртгэл хөтлөх

(10) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] энэ бүлгийн дагуу бүх тусгай зөвшөөрөл авсан хувь хүн, байгууллага, мэдээлэгдсэн барилга байгууламжийн бүртгэлийг үнэн зөв бөгөөд шуурхай хөтөлнө. Бүртгэлд тусгай зөвшөөрөл авсан хувь хүн, байгууллага, мэдээлэгдсэн барилга байгууламжийн нэр, байршил, хязгаарласан бодис эсвэл токсиньг боловсруулах, олж авах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх эсвэл ашиглах тусгай зөвшөөрөл авсан хувь хүн эсвэл байгууллага бүрийн талаар мэдээллийг оруулна.

⁴ Улс орнууд нь эдгээр зохицуулалтыг бэлтгэхдээ 2004 оны Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын лабораторийн биологийн аюулгүй байдлын гарын авлагатай (Гурав дахь хэвлэл) нийцүүлэн авч үзэхийг хүсэж болно.

⁵ Улс орнууд нь эдгээр зохицуулалтыг бэлтгэхдээ 2004 оны Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын лабораторийн биологийн аюулгүй байдлын гарын авлагатай (Гурав дахь хэвлэл) нийцүүлэн авч үзэхийг хүсэж болно.

Хулгайлах эсвэл алдагдах тухай мэдэгдэх

(11) Энэ бүлгийн дагуу тусгай зөвшөөрөл авсан хувь хүн, байгууллага (ба тэдгээрийн мэдээлэгдсэн барилга байгууламж) хязгаарласан бодис эсвэл токсин хулгай, алдагдлын тухай [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА], [ЗОХИХ ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГА], [[УЛСЫН НЭР] Биологийн Онцгой байдлын хариу арга хэмжээ, мөрдөн байцаах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх систем (BERISS)]-д яаралтай мэдэгдэнэ. Тусгай зөвшөөрөл авсан байгууллагууд мэдээлэгдсэн барилга байгууламжид гарсан хулгай, алдагдлын тухай мэдэгдэх журмыг боловсруулж болно.

Хязгаарлаагүй бодис эсвэл токсинтой холбоотой үйл ажиллагаанд зориулсан эрсдэлийн үнэлгээ

(12) дэд бүлэг (1)-ээс үл хамааран хязгаарлаагүй бодис эсвэл токсинг боловсруулж, үйлдвэрлэж, эзэмшиж, хадгалж, тээвэрлэж, шилжүүлж эсвэл ашигладаг аливаа хувь хүн, байгууллага эсвэл барилга байгууламж нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулж болзошгүй гэж үндэстэйгээр үзэж байгаа үйл ажиллагаа бүрийн хувьд энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар гаргасан дүрэм журамд заасны дагуу эрсдэлийн үнэлгээ хийнэ. Энэ эрсдэлийн үнэлгээг дүрэм журамд заасан хугацаанд [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-д ирүүлнэ.

12. Хязгаарласан бодис, токсинг дотоодод тээвэрлэхэд тавих хяналт

(1) Хязгаарласан бодис эсвэл токсинг [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ], түүний дагуу гаргасан аливаа бусад дүрэм журмын дагуу тусгай зөвшөөрөл авсан хувь хүмүүс ба байгууллагуудын (ба тэдгээрийн мэдээлэгдсэн байгууламж) хооронд [УЛСЫН НЭР] улсын газар нутгийн дотор зөвхөн тээвэрлэнэ.

(2) [УЛСЫН НЭР] улсын газар нутгийн доторх хязгаарласан бодис эсвэл токсин бүх санал болгож буй тээвэрлэлтийг энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн хүрээнд гаргасан дүрэм журмын дагуу [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-д урьдчилан мэдэгдэнэ.

(3) Хязгаарласан бодис, токсинтой онцгой анхаарал болгоомжтой харьцаж ажиллуулахын тулд [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-ын гаргасан дүрэм журамд тээвэрлэхэд тавих техникийн ба хамгаалалтын нэмэлт шаардлагуудыг тодорхой заана на. Нэмэлт шаардлагуудад хязгаарласан бодис, токсин байршлыг хянах, хүлээн авагч барааг хүлээн авсан тухай баталгаажуулах зэрэг багтана.

13. Олон улсад тээвэрлэхэд тавих хяналт

Хязгаарласан бодис, токсин, хязгаарласан тоног төхөөрөмж, технологийн импорт, экспорт, шилжүүлэн ачих

(1) Аливаа хязгаарласан бодис, токсин эсвэл хязгаарласан тоног төхөөрөмж, технологийг [УЛСЫН НЭР] улсын газар нутгаар дамжуулан импортолж, экспортолж, дахин экспортолж, шилжүүлэн ачдаг хувь хүн, байгууллага бүр [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА ЭСВЭЛ ҮНДЭСНИЙ ЭКСПОРТ/ИМПОРТЫН ХЯНАЛТЫН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас зөвшөөрөл авсан байна.

(2) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА ЭСВЭЛ ҮНДЭСНИЙ ЭКСПОРТ/ИМПОРТЫН ХЯНАЛТЫН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] хязгаарласан бодис,

токсин эсвэл хязгаарласан тоног төхөөрөмж, технологийг тээвэрлэх зөвшөөрлийг олж авах шаардлага, журмыг тодорхойлсон журмыг баталж гаргана.

(3) Хэрэв [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-д импортлогдсон, экспортлогдсон, дахин экспортлогдсон эсвэл шилжүүлэн ачигдсан хязгаарлаагүй бодис, токсин эсвэл хязгаарлаагүй тоног төхөөрөмж, технологийг энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар хориглосон зорилгоор ашигласан байж магадгүй гэж үзэх эсвэл сэжиглэх шалтгаан байгаа бол [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] импортлох, экспортлох, дахин экспортлох эсвэл шилжүүлэн ачихаас урьдчилан сэргийлэхийн тулд зохих шүүхийн эрх бүхий байгууллагад хандан шийдвэр гаргуулж болно.

Экспортын журам

(4) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА ЭСВЭЛ ҮНДЭСНИЙ ЭКСПОРТ/ИМПОРТЫН ХЯНАЛТЫН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] хязгаарласан бодис, токсин эсвэл хязгаарласан тоног төхөөрөмж, технологийг зөвхөн хязгаарласан бодис, токсин эсвэл хязгаарласан тоног төхөөрөмж, технологийн хувьд ижил зохицуулалттай улс орны хувь хүмүүс, байгууллага, байгууламж руу экспортлохыг зөвшөөрсөн журмыг батална.

(5) дэд бүлэг (4)д заасан журамд эцсийн хэрэглэгчийн гэрчилгээ авахыг шаардаж, үүнд наад зах нь дараах зүйлсийг багтаана.

- (a) Хязгаарласан бодис, токсин эсвэл хязгаарласан тоног төхөөрөмж, технологийг зөвхөн хууль ёсны зорилгоор ашиглах болно гэсэн мэдэгдэл;
- (b) Хязгаарласан бодис, токсин эсвэл хязгаарласан тоног төхөөрөмж, технологийг дамжуулан тээвэрлэхгүй гэсэн мэдэгдэл;
- (c) Шилжүүлэх хязгаарласан бодис, токсин төрөл, хэмжээ эсвэл хязгаарласан тоног төхөөрөмж, технологийн тодорхойлолт;
- (d) Шилжүүлэх хязгаарласан бодис, токсин эсвэл хязгаарласан тоног төхөөрөмж, технологийн эцсийн ашиглалт;
- (e) Эцсийн хэрэглэгч, аливаа зуучлагчийн нэрс, байршил.

Дамжин өнгөрөх

(6) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА ЭСВЭЛ ҮНДЭСНИЙ ЭКСПОРТ/ИМПОРТЫН ХЯНАЛТЫН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] [УЛСЫН НЭР] улсын газар нутгаар хязгаарласан бодис, токсин эсвэл хязгаарласан тоног төхөөрөмж, технологийг дамжин өнгөрүүлэхэд тавих шаардлага, журмыг тодорхойлсон дүрмийг батлан гаргана.

14. Хязгаарласан бодис ба токсин тээвэрлэлт

Зөвхөн зөвшөөрөгдсөн зөөвөрлөгчөөр шилжүүлэх

(1) 12 ба 13 дугаар бүлгийн дагуу хязгаарласан бодис ба токсин дотоод ба олон улсын шилжүүлгийг зөвхөн дэд бүлэг (2)-ын дагуу [ТЭЭВРИЙН ЯАМ ЭСВЭЛ ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас зөвшөөрсөн зөөвөрлөгчөөр гүйцэтгүүлнэ.

Зөвшөөрөгдсөн зөөвөрлөгч

(2) [ТЭЭВРИЙН ЯАМ ЭСВЭЛ ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] хязгаарласан бодис, токсин дотоод ба олон улсад тээвэрлэх зөвшөөрөлтэй тээвэрлэгчийн жагсаалтыг хөтөлнө. Жагсаалтад савлах, шошго тавих; ачааг дагах; хувь хүн, тээврийн хэрэгсэл, барилга байгууламжийн аюулгүй байдал, хамгаалалтын хамгийн сайн арга туршлагыг дагаж мөрддөг

болохоо [ТЭЭВРИЙН ЯАМ ЭСВЭЛ ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-д нотлон харуулсан тээвэрлэгчийг зөвхөн оруулна.

Тээврийн удирдамж

(3) Хязгаарласан бодис, токсины дотоодод болон олон улсад тээвэрлэх үйл ажиллагааг энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн дагуу [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас гаргасан аливаа дүрэм журам, [ТЭЭВРИЙН ЯАМ]-аас гаргасан аюултай материалыг тээвэрлэх удирдамж, савлах, шошго тавих удирдамжийн дагуу явуулна. [УЛСЫН НЭР] улсын газар нутгаар хязгаарласан бодис эсвэл токсиныг импортолж, экспортолж, дахин экспортолж, шилжүүлэн ачиж эсвэл дамжин өнгөрч байгаа тээвэрлэгч бүр аюултай материалын тээвэрлэлтэд зориулсан олон улсын холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөнө.

Хязгаарласан бодис эсвэл токсины хулгай, алдагдлын тухай мэдэгдэх

(4) Энэ бүлгийн дагуу хязгаарласан бодис, токсиныг дотооддоо эсвэл олон улсад тээвэрлэх зөвшөөрөл авсан тээвэрлэгч хязгаарласан бодис эсвэл токсины хулгай, алдагдлын тухай [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА], [ЗОХИХ ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГА], [[УЛСЫН НЭР] УЛСЫН БИОЛОГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ, МӨРДӨН БАЙЦААХ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ СИСТЕМ (BERISS)]-д яаралтай мэдэгдэнэ.

Г ХЭСЭГ ХУУЛЬ САХИУЛАХ

15. [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-г байгуулах, чиг үүрэг, хууль сахиулах эрх мэдэл

Үүсгэн байгуулах

(1) Энэ бүлэгт [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ], түүний дагуу гаргасан аливаа дүрэм журмыг мөрдүүлэх [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-ыг үүсгэн байгуулна.

Бүтэц⁶

(2) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] нь дараах этгээдээс бүрдэнэ.

- (a) [Ерөнхий сайд, Засгийн газрын тэргүүний] албаны төлөөлөгч, энэ төлөөлөгч мөн [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-ын даргын үүргийг гүйцэтгэнэ;
- (b) Гадаад хэргийн яамны төлөөлөгч;
- (c) Хууль зүйн яамны төлөөлөгч;
- (d) ‘
- (e) Аж үйлдвэрийн яамны төлөөлөгч;
- (f) Байгаль орчны яамны төлөөлөгч;
- (g) Эрүүл мэндийн яамны төлөөлөгч;
- (h) Хөдөө аж ахуйн яамны төлөөлөгч;
- (i) Дотоод хэргийн яамны төлөөлөгч;
- (j) Тээврийн яамны төлөөлөгч;
- (k) [ҮНДЭСНИЙ ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН] төлөөлөгч;
- (l)
- (m)

⁶ Энэ жагсаалт нь зөвхөн жишээ болох зорилготой бөгөөд тухайн улсын үндсэн хууль, хууль тогтоомжийн дэглэм, нөхцөл байдал, хэрэгцээнд тохируулан өөрчилбөл зохино.

- (n) [УЛСЫН ХИЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА (ГААЛЬ, БООМТЫН БАЙГУУЛЛАГА)]-ын төлөөлөгч;
- (o) [УЛСЫН НЭР] улсын худалдаа, аж үйлдвэрийн танхимын төлөөлөгч;
- (p) [УЛСЫН НЭР] улсын биологийн салбарын холбооны төлөөлөгч.

[ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-ын чиг үүрэг

(3) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] нь ил тод, хянаж болох байдлаар дараах чиг үүргийг гүйцэтгэнэ.

- (a) [УЛСЫН НЭР] улсын [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] байх;
- (b) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ], түүний дагуу гаргасан аливаа дүрэм журмыг сахиулах ажлыг удирдан хянах;
- (c) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ], түүний дагуу гаргасан аливаа дүрэм журмын дагуу тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох;
- (d) [УЛСЫН НЭР] улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор олон улсын байгууллага, бусад улсыг холбогдох өгөгдөл, мэдээллээр хангах;
- (e) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн дагуу хяналт шалгалт явуулах;
- (f) Хууль ёсны зорилгоор биологийн судалгаа явуулах удирдамжийг боловсруулах;
- (g) Биологийн онцгой байдлын хариу арга хэмжээ, мөрдөн байцаах ажиллагааг дэмжих системийг (BERISS) байгуулах, холбоо тогтоох, үйл ажиллагааг нь хянах;
- (h) Бусад улсын ижил төстэй [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-тай холбоо тогтоох;
- (i) Зохих эрх бүхий байгууллагаас даалгасан бусад аливаа үүргийг биелүүлэх;
- (j) Хариуцсан эрх бүхий байгууллага, Биологийн онцгой байдлын хариу арга хэмжээ, мөрдөн байцаах ажиллагааг дэмжих системийн (BERISS) үйл ажиллагааны талаар [ПАРЛАМЕНТ, ҮНДЭСНИЙ АССАМБЛЕЙ]-д жил бүр тайлагнах;
- (k) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-той холбоотой асуудлаар [ЕРӨНХИЙ САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮН]-д зөвлөгөө өгч, Ерөнхий сайд эсвэл бусад зохих байгууллагын шаардаж болох аливаа мэдээллээр хангах.

(4) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-тай холбоотой аливаа асуудлаар зөвлөгөө өгөхдөө ажлын хэсгийг томилж болно.

16. [[УЛСЫН НЭР] улсын биологийн онцгой байдлын хариу арга хэмжээ, мөрдөн байцаах ажиллагааг дэмжих системийн (BERISS)] байгуулах

Байгуулах

(1) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] [ЗОХИХ ХУУЛЬ САХИУЛАХ АГЕНТЛАГ]-т хүн, амьтан, ургамлын эрүүл мэндэд нөлөө үзүүлэх биологийн онцгой байдлын хариу арга хэмжээ, харилцаа холбоонд дэмжлэг үзүүлж, биологийн ослыг судлахад туслалцаа үзүүлэх [БИОЛОГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ, МӨРДӨН БАЙЦААХ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ СИСТЕМ (BERISS)]-ийг байгуулна.

BERISS-ын зохицуулах багийн бүтэц бүрэлдэхүүн

(2) BERISS-ыг удирдаж, зохицуулах багийн бүрэлдэхүүн

- (a) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА], BERISS-ын хооронд холбоо тогтоох үүргийг гүйцэтгэх [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-ын төлөөлөгч;
- (b) [ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ ЭСВЭЛ ХҮНС, ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АГЕНТЛАГ]-ын төлөөлөгч;
- (c) Хөдөө аж ахуйн яамны төлөөлөгч;
- (d) Байгаль орчны яамны төлөөлөгч;

- (e) Яаралтай тусламжийн эмч;
- (f) Биологийн онцгой нөхцөлд хариу арга хэмжээ авахад бэлтгэгдсэн [ЗОХИХ ХУУЛЬ САХИУЛАХ АГЕНТЛАГ]-ийн ажилтан;
- (g) [УЛСЫН ХИЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА (ГААЛЬ, БООМТЫН БАЙГУУЛЛАГА)]-ын төлөөлөгч;
- (h) Тархвар зүйч;
- (i) Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний ажилтан;
- (j) Хэвлэл мэдээллийн мэргэжилтэн;
- (k) Бактери, хор, вирус, яс зөөлрөх, прион өвчний мэргэжилтнүүд;
- (l) ДЭМБ-ын Олон улсын эрүүл мэндийн зохицуулалтын Үндэсний мэдээллийн байгууллага;
- (m) BERISS-ын зүгээс тохиромжтой гэж үзсэн аливаа бусад холбогдох мэргэжилтэн.

(3) BERISS-ын зохицуулах багийн гишүүдэд үндэсний аюулгүй байдал, хууль сахиулах болон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудтай хамтран ажиллах боломж олгох зохих зөвшөөрлийг авах шаардлагатай.

Чиг үүрэг, гүйцэтгэх ажил үүрэг

(4) BERISS-ын зохицуулах баг ил тод, хянаж болох байдлаар дараах үүргийг гүйцэтгэнэ.

- (a) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-тай хамтран биологийн бодис, токсинтой холбоотой онцгой байдалд авах үндэсний ба орон нутгийн хариу арга хэмжээг удирдан чиглүүлэх;
- (b) холбогдох бусад засгийн газрын агентлагтай хамтран хязгаарласан бодис, токсины боловсруулалт, худалдан авалт, үйлдвэрлэл, эзэмшил, хадгалалт, тээвэрлэлт, шилжүүлэлт эсвэл ашиглалттай холбогдуулж нийтийн эрүүл мэнд, хөдөө аж ахуйн тандалт, тайлагналтын системийг бий болгох;
- (c) улсын онцгой байдлыг зарлах системийн үр дүнтэй байдлыг хангах;
- (d) биологийн бодис, токсинтой холбоотой онцгой байдалд хариу арга хэмжээ авах [ХОЛБОГДОХ ХУУЛЬ САХИУЛАХ АГЕНТЛАГ]-ын ажилтнууд, яаралтай/анхны хариу арга хэмжээ авах хүмүүс, эмнэлгийг зохих сургалтад хамруулж, тоног төхөөрөмжөөр хангах;
- (e) биологийн бодис, токсинтой холбоотой дэгдэлтийг илрүүлж тодорхойлохын тулд аюулд суурилсан эмнэлгийн ба нийтийн эрүүл мэндийг илрүүлэх стратегийг боловсруулах;
- (f) биологийн аюул заналын тухай тагнуулын нууц мэдээллийг хүлээн авч хянах;
- (g) нийтийн эрүүл мэндийн мэдээллийг хүлээн авч хянах;
- (h) шүүхийн тархвар зүйн мөрдөн байцаах ажиллагааг хянах, яллахад шаардлагатай нотолгоог цуглуулах, хадгалах, танилцуулах;
- (i) биологийн онцгой байдал, ослын талаар өгөгдөл, мэдээллийг [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-д дамжуулах;
- (j) 2005 оны олон улсын эрүүл мэндийн дүрмийг мөрдөхөөр үндэсний байгууллагаар дамжуулан Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах;
- (k) биологийн бодис, токсинтой холбоотой онцгой байдалд бэлэн байж, хариу арга хэмжээ авахтай холбоотой бусад үйл ажиллагааг явуулах. Үүний дотор [ХОЛБОГДОХ ХУУЛЬ САХИУЛАХ АГЕНТЛАГ]-ын ажилтантай хамтран ажиллах.

Дүрэм журам

(5) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] BERISS-ийг байгуулж ажиллуулах дүрэм журмыг гаргах эрхтэй байна.

17. Бүртгэл хөтлөх, тайлагнах, холбогдох зөрчил

Зорилго

(1) Энэ бүлгийн зорилго дараах нөхцөлийг хангахад оршино –

- (a) хязгаарласан бодис, токсиньг зөвхөн хууль ёсны зорилгоор боловсруулж, худалдан авч, үйлдвэрлэж, эзэмшиж, хадгалж, тээвэрлэж, шилжүүлж эсвэл ашиглах;
- (b) хязгаарласан бодис, токсиньг боловсруулж, худалдан авч, үйлдвэрлэж, эзэмшиж, хадгалж, тээвэрлэж, шилжүүлж эсвэл ашиглаж байгаа барилга байгууламж аюулгүй байх.

(2) Энэ бүлэгт заасан аливаа эрх мэдлийг зөвхөн дэд бүлэг (1)-д заасан зорилгоор хэрэгжүүлж болно.

Бүртгэл хөтлөх, мэдээллээр хангах

(3) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ], түүний дагуу гаргасан дүрэм журамд нийцүүлэн хувь хүн, байгууллага, тээвэрлэгч бүр -

- (a) Хувь хүн, байгууллага, тээвэрлэгчийн үйл ажиллагаа явуулдаг газар эсвэл [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-ын тогтоож болох бусад газарт дүрэм журамд заасан өгөгдөл, мэдээлэл, баримт бичгийг дүрэм журмаар тогтоосон хугацаанд болон хэлбэрээр хадгалж, хөтөлнө;
- (b) Дүрэм журамд заасны дагуу эдгээр өгөгдөл, мэдээлэл, баримт бичгээс тайлан бэлтгэх;
- (c) Дүрэм журамд заасан маягтаар болон хугацаанд [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] эсвэл зохицуулалтад заасан бусад аливаа эрх бүхий байгууллагыг эдгээр тайлангаар хангах.

Мэдээллийг ил болгох тухай мэдэгдэл

(4) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ыг сахиулахтай холбоотой өгөгдөл, мэдээлэл эсвэл баримт бичиг байгаа гэж боломжийн үндэслэлээр үзэж байгаа хувь хүн, байгууллага эсвэл тээвэрлэгчид [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас өгөгдөл, мэдээлэл, баримт бичгийг өгөхийг хүссэн мэдэгдлийг хүргүүлж болно.

(5) дэд бүлэг (4)-т дурдсан мэдэгдлийг хүлээн авсан хувь хүн, байгууллага эсвэл тээвэрлэгч мэдэгдэлд заасан маягтаар тухайн хугацаанд багтаан өөрсдийн мэдэл эсвэл хяналтад байгаа хүссэн өгөгдөл, мэдээлэл, баримт бичгийг [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-д өгнө.

[ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] мэдээллийг дамжуулах

(6) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ын дагуу олж авсан холбогдох өгөгдөл, мэдээллийг бусад улсын ба олон улсын байгууллагад дамжуулах эрхтэй байна.

Зөрчил

(7) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-ыг аливаа өгөгдөл, мэдээлэл эсвэл баримт бичгээр хангаагүй эсвэл аливаа өгөгдөл, мэдээлэл, баримт бичиг эсвэл энэ бүлэгт заасны дагуу бэлтгэсэн тайланд худал эсвэл төөрөгдүүлсэн мэдээлэл оруулсан этгээд бүрийг зөрчил гаргасанд тооцно.

(8) Тодорхой асуудлыг орхигдуулснаар аливаа өгөгдөл, мэдээлэл, баримт бичиг эсвэл энэ бүлэгт заасны дагуу бэлтгэсэн тайланг худал эсвэл төөрөгдүүлсэн болгоно гэдгийг мэдсээр байж ийнхүү орхигдуулсан этгээд бүрийг зөрчил гаргасандтооцно.

(9) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ] эсвэл түүний дагуу гаргасан аливаа дүрэм журмын дагуу өгөгдөл, мэдээлэл, баримт бичиг эсвэл тайланг олж авсан бөгөөд бичгээр зөвшөөрөл авалгүйгээр тухайн өгөгдөл, мэдээлэл, баримт бичиг эсвэл тайланг аливаа хэлбэрээр хэн нэгэнд дамжуулсан этгээд бүрийг зөрчил гаргасандтооцно. Дараах тохиолдол үүнд хамаарахгүй.

- (a) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ] эсвэл түүний дагуу гаргасан аливаа дүрэм журмыг хэрэгжүүлэх эсвэл сахиулах зорилгоор үүнд эрүүгийн мөрдөн байцаалт, тагнуулын үнэлгээний зорилгоор;
- (b) [УЛСЫН НЭР]-ын олон улсын өмнө хүлээсэн үүргийн дагуу эсвэл
- (c) өгөгдөл, мэдээлэл, баримт бичиг эсвэл тайланг нийтийн аюулгүй байдлыг хангах ашиг сонирхлын үүднээс задруулах эсвэл мэдээлэхийг шаардсан хэмжээгээр.

18. Хяналт шалгалт

Зорилго

(1) Энэ бүлгийн дагуу [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ] эсвэл түүний дагуу гаргасан аливаа дүрэм журмыг хэрэгжүүлж, холбогдох био аюулгүй байдлын арга хэмжээг авахын тулд энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-д захирагдан хувь хүн, байгууллага (ба тэдгээрийн барилга байгууламж)-д хяналт шалгалт явуулах эрхтэй.

Байцаагчийг томилох

(2) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийг сахиулах зорилгоор хүмүүс эсвэл бүлэг хүмүүсийг⁷ байцаагчаар томилж болох ба хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулах нөхцөлийг тогтоож болно.

Хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах

(3) Байцаагч нь дараах нөхцөлийг хангах зорилгоор аливаа байрыг эзэмшиж байгаа хүний зөвшөөрөлтэйгөөр эсвэл шүүхийн шийдвэрийн дагуу байранд нэвтэрч, дэд бүлэг (4)-т заасан аливаа эрхийг хэрэгжүүлнэ.

- (a) энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн заалтууд, түүний дагуу гаргасан аливаа дүрэм журмыг мөрдсөн эсвэл мөрдөж байгаа; эсвэл
- (b) энэ 11 эсвэл 13 дугаар бүлгийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эсвэл зөвшөөрлийн холбогдох нөхцөлийг тусгай зөвшөөрөл буюу зөвшөөрөл эзэмшигч мөрдсөн эсвэл мөрдөж байгаа.

Эрх

(4) Хяналт шалгалт явуулах байцаагч нь дараах эрхтэй.

- (a) аливаа байрыг нэгжих;

⁷ Улс орнууд лаборатори, бусад байгууламжид био аюулгүй ажиллагаа, био аюулгүй байдлыг хариуцдаг ажилтнууд, био аюулгүй ажиллагаа, био аюулгүй байдлын онцгой байдалд хариу арга хэмжээ авахад бэлтгэгдсэн хууль сахиулах ажилтнуудыг энэ бүлэгт заасан зорилгоор хяналт шалгалтын багийн гишүүнээр томилж болно.

- (b) байранд зураг авах эсвэл видео бичлэг хийхийг зөвшөөрсөн аюулгүй ажиллагааны дүрэм журам хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нөхцөлд байранд эсвэл байрны эргэн тойронд аливаа гэрэл зургийн эсвэл видео бичлэгийн тоног төхөөрөмжийг ажиллуулах;
- (c) байцаагч хяналт шалгалтад туслах боломжтой гэж үзсэн аливаа хүнийг оролцуулахыг шаардах, асуулт тавих;
- (d) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийг сахиулахтай холбоотой гэж байцаагчийн үзсэн аливаа бодис, бүлэгт үзлэг хийх буюу шалгах, дээж авах, хураах эсвэл устгах;
- (e) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа мэдээллийг агуулсан гэж байцаагчийн үзсэн аливаа баримт бичгийг өгөх эсвэл хуулбарлаж өгөхийг аливаа этгээдээс шаардах;
- (f) аливаа өгөгдөл эсвэл бүртгэл, тооцооны дэвтэр, бусад баримт бичгийг хуулбарлахдаа тухайн газар байгаа аливаа тоног төхөөрөмжийг ашиглах эсвэл ашиглуулах;
- (g) компьютер эсвэл системд байх боломжтой эсвэл агуулагдсан аливаа өгөгдлийг шалгахдаа аливаа компьютер эсвэл өгөгдөл боловсруулах системийг ашиглах эсвэл ашиглуулах;
- (h) өгөгдлөөс хэвлэмэл эсвэл өөр бусад тодорхой хэлбэрээр аливаа бүртгэлийг хуулбарлах эсвэл хуулбарлуулах, хяналт шалгалт эсвэл хуулбарлахад зорилгоор хэвлэмэл эсвэл бусад материалыг авч явах;
- (i) тухайн байранд байрлах цахим тоног төхөөрөмж, мөн аливаа тоног төхөөрөмжийг ажиллуулах;
- (j) байцаагчийн сонгосон бөгөөд [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас эрх олгосон зохих шинжээчтэй хамт ажиллах;
- (k) байцаагчийн зүгээс зохистой гэж үзсэн бусад аливаа үндэслэлтэй арга хэмжээг авахыг байрыг эзэмшиж буй аливаа этгээдээс шаардах.

(5) Байрыг эзэмшиж байгаа этгээд боломжийн үндэслэлээр, аюулгүй ажиллагааны журмын дагуу байранд тохиромжтой гэж үзсэн тохиолдолд дэд бүлэг (4)-т илэрхийлэгдсэн эрхийг зөвхөн эдэлж болно.

Хяналт шалгалт явуулах зөвшөөрөл

(6) Байрыг эзэмшиж байгаа этгээдээс дэд бүлэг (3)-ын дагуу зөвшөөрөл авах боломжгүй эсвэл татгалзсан бол байцаагч зөвшөөрөл олгох хүсэлт гаргаж болно.

(7) [ЭНХТАЙВНЫ ШҮҮХ, МАГИСТРАТ ШҮҮХ] зөвшөөрөлд заасан аливаа нөхцөлийн дагуу байранд нэвтрэх эрхийг зөвшөөрөлд нэр заасан байцаагчид олгож болно. Гэхдээ [ЭНХТАЙВНЫ ШҮҮХ, МАГИСТРАТ ШҮҮХ] дараах нөхцөл боломжийн үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд зөвшөөрлийг олгоно.

- (a) дэд бүлэг (1)-ийн зорилгоор байранд нэвтрэх шаардлагатай;
- (b) байранд нэвтрэх зөвшөөрөл авч чадаагүй эсвэл татгалзсан эсвэл нэвтрүүлэхээс татгалзана гэсэн хангалттай үндэслэл байгаа.

19. Байцаагчийн үүрэг

Үнэмлэх

(1) [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-ын байцаагч, шинжээч эсвэл төлөөлөгчид үнэмлэх олгоно.

(2) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн дагуу аливаа байранд нэвтрэх [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-ын байцаагч, шинжээч эсвэл төлөөлөгч боломжтой үед байрыг эзэмшижбайгаа этгээдийн хүсэлтээр үнэмлэхээ үзүүлнэ.

Нэвтрэх, хураах тухай мэдэгдэл

(3) Байцаагч бүр байранд нэвтрэх цаг болон хяналт шалгалтыг дуусгах цагийн хооронд ямар ч хугацаанд байрыг эзэмшиж байгаа гэж харагдах ямар ч хүн байхгүй байсан гэдгийг мэдэгдсэн бичгээр үйлдсэн мэдэгдлийг байрыг эзэмшиж байгаа этгээдэд хяналт шалгалт дууссанаас хойш аль болох хурдан өгөх бөгөөд мэдэгдэлд дараах зүйлсийг тодорхой заана.

- (a) нэвтэрсэн цаг, огноо;
- (b) нэвтэрсэн зорилго, нөхцөл байдал;
- (c) нэвтэрсэн хүн бүрийн нэр.

(4) Байцаагч бүр (3) дугаар дэд бүлгийн дагуу аливаа баримт бичгийн хуулбарыг [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-д өгнө.

(5) Байцаагч бүр шаардлагатай тохиолдолд зөвшөөрлөө биедээ авч явж, шаардлагатай үед үзүүлнэ. Мөн байцаагч бүр ямар нэг зүйл хураан авсан бол хураан авсан бүх зүйлийн бичгээр үйлдсэн бүртгэлийг байрыг эзэмшиж байгаа этгээдэд өгнө.

Байцаагчийн тайлан ба мөрдөн байцаалтад шилжүүлэх

(6) Байцаагч бүр [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-д хяналт шалгалтын тайлан өгч, энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ] эсвэл түүний дагуу гаргасан дүрэм журмын аливаа сэжиг бүхий зөрчлийг бичнэ. [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] сэжиг бүхийн зөрчилтэй тохиолдлуудыг 22-р бүлгийн дагуу [ХОЛБОГДОХ ХУУЛЬ САХИУЛАХ АГЕНТЛАГ]-ын мөрдөн байцаалтад шилжүүлнэ.

20. Байрыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн үүрэг, холбогдох зөрчил

Байцаагчид туслалцаа үзүүлэх

(1) 18 дугаар бүлгийн дагуу нэвтэрсэн байрыг хяналтдаа байлгаж байгаа этгээд, байранд байсан хүн бүр байцаагч, хамт яваа аливаа шинжээчид үүргээ гүйцэтгэх боломжийг олгохын тулд боломжтой бүх туслалцааг үзүүлэх бөгөөд байцаагчийн гаргасан хүсэлтийн дагуу энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа мэдээллээр түүнийг хангана.

Бичгээр өгөх үүрэг чиглэл

(2) [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] нь 18 дугаар бүлгийн дагуу хяналт шалгалт хийхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор аливаа этгээдэд бичгээр үйлдсэн мэдэгдэл бүхий чиглэлийг гаргаж болно.

Зөрчил

(3) Дэд бүлэг (2)-ийн дагуу [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас өгсөн үндэслэлтэй аливаа үүрэг чиглэлийг биелүүлээгүй этгээд бүрийг зөрчил үйлдсэнд тооцно.

(4) Өгөгдсөн үүрэг эсвэл 18 дугаар бүлэгт заасан эрх мэдлээ хэрэгжүүлж байгаа аливаа байцаагч эсвэл аливаа байцаагчтай хамт яваа шинжээчид саад учруулах, эсэргүүцэх, хууран мэхлэх эсвэл худал эсвэл төөрөгдүүлсэн мэдээлэл өгсөн этгээд бүрийг зөрчил гаргасанд тооцно.

(5) 18 дугаар бүлгийн дагуу хураагдсан аливаа зүйлийг байцаагчийн зөвшөөрөлгүйгээр ямар нэг байдлаар устгах, өөрчлөх эсвэл саад болсон этгээд бүрийг зөрчил гаргасан хтооцно.

21. Аюулгүй байдлын арга хэмжээ авах шаардлагатай чиглэл, холбогдох зөрчил

(1) [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] хувь хүн эсвэл барилга байгууламжийн хувьд хуулийн хэрэгжилт хариуцсан ажилтанд дараах зүйлсийг шаардсан үүрэг чиглэлийг бичгээр өгч болно.

- (a) хязгаарласан бодис, токсин эсвэл хязгаарласан тоног төхөөрөмж, технологийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;
- (b) аливаа аюулгүй байдлын төлөвлөгөөг хянаж шинэчлэх;
- (c) [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас үндэслэлтэйгээр шаардаж болох бусад аливаа арга хэмжээг авах.

(2) Хэрэв аливаа холбогдох байранд хадгалагдаж эсвэл ашиглагдаж байгаа хязгаарласан бодис, токсин эсвэл хязгаарласан тоног төхөөрөмж, технологийн аюулгүй байдлыг хангах зохих арга хэмжээ аваагүй эсвэл авах магадлалгүй гэж үзэх хангалттай үндэслэл [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-д байгаа бол хувь хүн эсвэл барилга байгууламжийн хуулийн хэрэгжилт хариуцсан ажилтанд эдгээр зүйлийг устгах эсвэл зайлуулахыг шаардсан үүрэг чиглэлийг бичгээр өгч болно. Тухайн зүйлсийг хэзээ, хэрхэн устгах эсвэл зайлуулахыг үүрэг чиглэлд тодорхой заана.

Зөрчил

(3) Дэд бүлэг (1) эсвэл (2)-ын дагуу [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас өгсөн үүрэг чиглэлийг биелүүлээгүй этгээд бүрийг зөрчил гаргасанд тооцно.

22. Мөрдөн байцаах ажиллагаа

Зорилго

(1) Энэ бүлгийн зорилго энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн дагуу сэжиг бүхий зөрчлийг мөрдөн байцаах явцад [ХОЛБОГДОХ ХУУЛЬ САХИУЛАХ АГЕНТЛАГ], [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] ба BERISS-ийн хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Мөрдөн байцаах ажиллагаа

(2) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийг зөрчсөн гэж сэжиглэх тохиолдолд [ХОЛБОГДОХ ХУУЛЬ САХИУЛАХ АГЕНТЛАГ] [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] ба BERISS-тэй хамтран ажиллах замаар сэжиг бүхий зөрчлийн мөрдөн байцаах ажиллагааг удирдан явуулах эрхтэй байна.

(3) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн дагуу [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА], BERISS, хувь хүн, байгууллага эсвэл тээвэрлэгч нарт хадгалагдаж байгаа аливаа бүртгэл мэдээллийг энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн дагуу сэжиг бүхий зөрчлийг мөрдөн байцааж байгаа [ХОЛБОГДОХ ХУУЛЬ САХИУЛАХ АГЕНТЛАГ]-ийн хууль сахиулах ажилтан үзэж танилцах боломжтой байна.

(4) Хяналт шалгалт буюу мөрдөн байцаалтын явцад цуглуулсан аливаа дээжид энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар гаргасан дүрэм журам эсвэл бусад аливаа [АКТ,

ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн дагуу шинжилгээ хийж, шинжилгээний үр дүнг шүүх үйл ажиллагаанд нотлох баримт болгон ашиглаж болно.

Сургалт

(5) [ХОЛБОГДОХ ХУУЛЬ САХИУЛАХ АГЕНТЛАГ]-ийн хууль сахиулах ажилтныг энэ бүлгийн дагуу мөрдөн байцаалт хийхэд сургаж бэлтгэхийн тулд BERISS-ийн зохион байгуулах биологийн онцгой байдалд хариу арга хэмжээ авах чиглэлээр сургалтад хамруулна. Үүнд –

- (a) био терроризмын талаарх ерөнхий мэдээлэл;
- (b) биологийн онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үндэсний ба олон улсын хууль эрх зүйн орчин, биологийн ба токсины зэвсгийн тухай конвенцын ойлголт, биологийн бодис, токсинтой холбоотой хориглосон үйл ажиллагаа;
- (c) хувийн хамгаалалтын хэрэгслийн зохистой хэрэглээ;
- (d) бусад холбогдох аюулгүй ажиллагааны журмууд;
- (e) хамтарсан ярилцлага, нийтийн эрүүл мэндийн ажилтнуудтай бүртгэл хөтлөх гэх мэт мөрдөн байцаалтын төрөлжсөн аргачлал;
- (f) бодисыг тархахаас сэргийлэх арга хэмжээ;
- (g) биологийн аюулын үнэлгээ;
- (h) дээж авах зэрэг нотлох баримт цуглуулах, солж авах ажиллагаа;
- (i) хадгалалт, хамгаалалтын сүлжээ зэрэг нотлох баримттай холбоотой журам.

23. Хурааж устгах

(1) [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА БУЮУ ХОЛБОГДОХ ХУУЛЬ САХИУЛАХ АГЕНТЛАГ] дараах эрхийг олгох шүүхийн зөвшөөрлийг хүсэж болно.

- (a) энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар хориглосон аливаа үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн биологийн бодис, токсин эсвэл тоног төхөөрөмж, технологийг хураах;
- (b) энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар хориглосон аливаа үйл ажиллагаатай холбоотой мөнгөн хөрөнгийг хураах эсвэл гүйлгээг зогсоох.

(2) Хойшлуулшгүй тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүйгээр [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА]-аас энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар хориглосон аливаа үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн биологийн бодис, токсин эсвэл тоног төхөөрөмж, технологийг хураах эрх олгож болно.

(3) Эрх бүхий нэхэмжлэл гаргагчид мэдэгдсэний дараа ба шүүх хуралдаан явуулах боломж олгосны дараа дэд бүлэг (1) ба (2)-ын дагуу хураагдсан өмч хөрөнгийг Засгийн газар хурааж авна. [Энэхүү шүүх хурал дээр хураагдсан өмч хөрөнгө нь [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар хориглосон ажиллагаанд хамаарахыг нотлох баримтын давамгайллаар нотлох үүргийг Засгийн газар хүлээнэ].

(4) [ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] энэ бүлгийн дагуу хураагдсан аливаа биологийн бодис, токсин эсвэл тоног төхөөрөмж, технологийг устгах эсвэл бусад зохистой байдлаар зайлуулж болно.

24. Тодорхой үйл ажиллагааг зогсоох шүүхийн шийдвэр

[ХАРИУЦСАНЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] Б хэсгийн дагуу хориглосон ажиллагааны эсрэг зохих шүүхийн эрх бүхий байгууллагаас тодорхой үйл ажиллагааг зогсоох шүүхийн шийдвэр гаргуулж болно.

25. Үргэлжлүүлэн үйлдсэн гэмт хэрэг

[Хэрэв энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар гэмт хэргийг нэгээс олон өдөр үйлдсэн эсвэл үргэлжилсэн бол яллагдагч этгээд гэмт хэрэг үйлдсэн эсвэл үргэлжлүүлсэн өдөр тус бүрд тусдаа гэмт хэрэгт шийтгүүлнэ.]

26. Эрүүгийн болон иргэний шийтгэл

Хувь хүн, байгууллагын хүлээх эрүүгийн хариуцлага

(1) [УЛСЫН НЭР]-ын эрүүгийн, тусгай зөвшөөрлийн, шилжүүлэх хяналтын хууль зэрэг хуулийн бусад заалтын дагуу оноож болох аливаа ял шийтгэлээс гадна энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн Б, В ба Г хэсэг болон түүний дагуу гаргасан дүрэм журмыг зөрчсөн хувь хүн, байгууллагад дэд хэсэг (3)-(8)-ын ял шийтгэлийг онооно.

Байгууллагын захирал, менежер, нарийн бичгийн дарга, бусад ажилтанд хүлээлгэх хариуцлага

(2) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар гэмт хэргийг байгууллага үйлдсэн бөгөөд аливаа захирал, менежер, нарийн бичгийн дарга, байгууллагын бусад ижил төстэй үүрэг бүхий ажилтны зөвшөөрлөөр болон ятгалгаар үйлдэгдсэн гэдэг нь нотлогдсон эсвэл захирал, менежер, нарийн бичгийн дарга, байгууллагын бусад ижил төстэй үүрэг бүхий ажилтны зүгээс хайхрамжгүй хандсантай холбоотой гэдэг нь нотлогдсон эсвэл хэн нэгэн эрх мэдлээ ашиглан үйлдэхийг завдсан гэдэг нь нотлогдсон бол тухайн этгээд, байгууллага энэ гэмт хэрэгт яллагдаж, энэ бүлэгт заасны дагуу үүсгэсэн хэргийн хариуцлагыг хүлээж, шийтгэгдэнэ.

Биологийн бодис, токсины зүй бус ашиглалт

(3) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн 5 дугаар бүлгийн дагуу гэмт хэрэг үйлдсэн хүн бүр гэмт хэрэгт яллагдаж, гэм буруутай нь тогтоогдвол дараах ял шийтгэл хүлээнэ. –

- (a) хувь хүний хувьд [ХУГАЦАА] жилээс ихгүй хугацаагаар хорих ял оноож эсвэл [МӨНГӨН ДҮН]-ээс хэтрэхгүй хэмжээгээр торгох эсвэл хорих ял, торгуулийг хоёуланг ногдуулна;
- (b) хувь хүний хувьд гэмт хэрэг үхэлд хүргэсэн бол [БҮХ НАСААР ХОРИХ] ял онооно;
- (c) байгууллагын хувьд [МӨНГӨН ДҮН]-ээс хэтрэхгүй торгууль ногдуулна.

(4) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн 6 дугаар бүлгийн дагуу гэмт хэрэг үйлдсэн хүн бүр гэмт хэрэгт яллагдаж, гэм буруутай нь тогтоогдвол дараах ял шийтгэл хүлээнэ. –

- (a) хувь хүний хувьд [ХУГАЦАА] жилээс ихгүй хугацаагаар хорих ял оноож эсвэл [МӨНГӨН ДҮН]-ээс хэтрэхгүй хэмжээгээр торгох эсвэл хорих ял, торгуулийг хоёуланг ногдуулна;
- (b) хувь хүний хувьд гэмт хэрэг үхэлд хүргэсэн бол [БҮХ НАСААР ХОРИХ] ял онооно;
- (c) байгууллагын хувьд [МӨНГӨН ДҮН]-ээс хэтрэхгүй торгууль ногдуулна.

(5) Дэд бүлэг (3) эсвэл (4)-ийн дагуу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тохиолдолд 11 эсвэл 13 дугаар бүлгийн дагуу зохих ёсоор олгосон тусгай зөвшөөрөл эсвэл зөвшөөрлийг эзэмшиж байгаа хувь хүн эсвэл байгууллага тусгай зөвшөөрөл эсвэл зөвшөөрөлд жагсаасан хязгаарласан бодис эсвэл токсиньг боловсруулах, худалдан авах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх эсвэл ашиглах хууль ёсны зорилготой байсан гэсэн *өнгөц* таамаглал байна.

Бүртгэл хөтөлж тайлагнах

(6) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн 17 дугаар бүлгийн дагуу гэмт хэрэг үйлдсэн хүн бүр гэмт хэрэгт яллагдаж, гэм буруутай нь тогтоогдвол дараах ял шийтгэл хүлээнэ. –

- (a) хувь хүний хувьд [ХУГАЦАА] жилээс ихгүй хугацаагаар хорих ял оноож эсвэл [МӨНГӨН ДҮН]-ээс хэтрэхгүй хэмжээгээр торгох буюу хорих ял, торгуулийг хоёуланг ногдуулна;
- (b) байгууллагын хувьд [МӨНГӨН ДҮН]-ээс хэтрэхгүй торгууль ногдуулна.

Шалгасан байрыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн үүрэг

(7) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн 20 дугаар бүлгийн дагуу гэмт хэрэг үйлдсэн хүн бүр гэмт хэрэгт яллагдаж, гэм буруутай нь тогтоогдвол дараах ял шийтгэл хүлээнэ. –

- (a) хувь хүний хувьд [ХУГАЦАА] жилээс ихгүй хугацаагаар хорих ял оноож эсвэл [МӨНГӨН ДҮН]-ээс хэтрэхгүй хэмжээгээр торгох эсвэл хорих ял, торгуулийг хоёуланг ногдуулна;
- (b) байгууллагын хувьд [МӨНГӨН ДҮН]-ээс хэтрэхгүй торгууль ногдуулна.

Хамгаалалтын арга хэмжээ шаардсан чиглэл

(8) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн 21 дугаар бүлгийн дагуу гэмт хэрэг үйлдсэн хүн бүр гэмт хэрэгт яллагдаж, гэм буруутай нь тогтоогдвол дараах ял шийтгэл хүлээнэ. –

- (a) хувь хүний хувьд [ХУГАЦАА] жилээс ихгүй хугацаагаар хорих ял оноож эсвэл [МӨНГӨН ДҮН]-ээс хэтрэхгүй хэмжээгээр торгох эсвэл хорих ял, торгуулийг хоёуланг ногдуулна;
- (b) байгууллагын хувьд [МӨНГӨН ДҮН]-ээс хэтрэхгүй торгууль ногдуулна.

27. Хэрэгжилт

(1) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ] нь дараах тохиолдолд үйлчилнэ –

- (a) [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар хориглосон үйлдэл эсвэл эс үйлдлийг [УЛСЫН НЭР] улсын нутаг дэвсгэрт аливаа иргэн, хуулийн этгээд үйлдсэн;
- (b) [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар хориглосон үйлдэл эсвэл эс үйлдлийг [УЛСЫН НЭР] улсын нутаг дэвсгэрийн гадна [УЛСЫН НЭР]-ын иргэн үйлдсэн;
- (c) [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар хориглосон үйлдэл эсвэл эс үйлдлийг [УЛСЫН НЭР] улсын усан онгоц, нисэх онгоцонд үйлдсэн;
- (d) [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар хориглосон үйлдэл эсвэл эс үйлдлийг [УЛСЫН НЭР] улсын нутаг дэвсгэрт байнга оршин сууж байгаа харьяалалгүй иргэн эсвэл оршин суугч үйлдсэн;

- (e) [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар хориглосон үйлдэл эсвэл эс үйлдлийг [УЛСЫН НЭР] эсвэл түүний иргэдийг хорлох зорилгоор эсвэл [УЛСЫН НЭР] улсаар ямар нэгэн үйлдэл хийлгэх эсвэл хийхээс түдгэлзүүлэх зорилгоор үйлдсэн;
- (f) [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-аар хориглосон үйлдэл эсвэл эс үйлдлийн хохирогч нь [УЛСЫН НЭР] улсын иргэн байсан.

(2) Дэд хэсэг (1)(с)-ийн зорилгоор "[УЛСЫН НЭР] улсын усан онгоц, нисэх онгоц" гэдгийг [УЛСЫН НЭР] улсын нэр дээр бүртгэгдсэн, тус улсад харьяалагддаг эсвэл эзэмшилд нь байдаг усан онгоц, нисэх онгоц гэж ойлгоно.

28. Эрх зүйн хамтын ажиллагаа, туслалцаа

(1) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн Б хэсэгт заасан гэмт хэргүүдийг [УЛСЫН НЭР], бусад улсын хооронд байгуулсан гэмт хэрэгтнийг шилжүүлэх тухай гэрээний дагуу шилжүүлбэл зохих гэмт хэрэг гэж тооцно.

(2) Дэд бүлэг (1)-ээс үл хамааран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах, энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийг хэрэгжүүлэх [УЛСЫН НЭР] улсын эрх бүхий байгууллага бусад улсын эрх бүхий байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллаж болох ба бусад улсын байгууллага, олон улсын байгууллагын албан ёсны нууцыг хадгалж, энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ] эсвэл ижил төстэй гадаадын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэмжээгээр өөрсдийн үйл ажиллагааг уялдуулж болно.

(3) [УЛСЫН НЭР] улсын эрх бүхий байгууллага дэд хэсэг (2)-ын дагуу бусад улсын байгууллага, олон улсын байгууллагаас холбогдох өгөгдөл эсвэл мэдээлэл өгөхийг хүсэж болно. [УЛСЫН НЭР] улсын эрх бүхий байгууллага дараах зүйлийн талаар өгөгдөл эсвэл мэдээлэл хүлээн авах эрхтэй.

- (a) хязгаарласан эсвэл хязгаарлаагүй биологийн бодис, токсин боловсруулах, худалдан авах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх эсвэл ашиглар;
- (b) хязгаарласан эсвэл хязгаарлаагүй хоёрдмол хэрэглээтэй биологийн тоног төхөөрөмж, технологи;
- (c) дэд хэсэг (a), (b)-д заасан зүйлд оролцсон хувь хүн.

(4) Хэрэв тухайн улс [УЛСЫН НЭР] улстай харилцан туслалцах зохих гэрээ байгуулсан бол [УЛСЫН НЭР] улсын эрх бүхий байгууллага өөрийн санаачлагаар эсвэл тухайн улсын хүсэлтээр дэд хэсэг (3)-т тодорхойлсон өгөгдөл эсвэл мэдээллийг тухайн улсад өгч болох ба ингэхдээ нөгөө улсын эрх бүхий байгууллага эдгээр өгөгдөл эсвэл мэдээллийг зөвхөн дараах зүйлд ашиглана гэсэн баталгаа өгсөн тохиолдолд гаргаж өгнө –

- (a) энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-д нийцсэн зорилгоор зөвхөн ашиглах
- (b) олон улсын шүүхийн хамтын ажиллагааг зохицуулдаг заалтуудын дагуу өгөгдөл эсвэл мэдээллийг олж авсан нөхцөлд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд зөвхөн ашиглах.

(5) Хэрэв дэд хэсэг (4)-т заасан нөхцөлүүдийг хангасан бол [УЛСЫН НЭР] улсын эрх бүхий байгууллага дэд хэсэг (3)-т тодорхойлсон өгөгдөл эсвэл мэдээллийг олон улсын байгууллагад өгч болох ба энэ тохиолдолд харилцан туслах гэрээний шаардлагуудыг мөрдөхгүй.

(6) Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн Б хэсэгт заасан аль ч гэмт хэргийг энэ хэсгийн дагуу гэмт хэрэгтнийг шилжүүлэх эсвэл эрх зүйн хамтын ажиллагаа, туслалцааны зорилгоор улс төрийн гэмт хэрэг, улс төрийн гэмт хэрэгтэй холбоотой гэмт хэрэг эсвэл улс төрийн сэдэлтэй гэмт хэрэг гэж үзэхгүй.

Д ХЭСЭГ ДҮРЭМ ЖУРАМ

29. Дүрэм журам

Энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн өөр зүйл заалтуудад шаардагдах дүрэм журмаас гадна [ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА] эсвэл энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-тай холбогдуулан эрх мэдэл бүхий сайд энэ [АКТ, ТОГТООМЖ, ТОГТООЛ, ХУУЛЬ]-ийн заалтууд, зорилгуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад дүрэм журмыг гаргаж болно.
